



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

|   |   |              |  |
|---|---|--------------|--|
|  | Гал тогооны<br>ажилтны аюулгүй<br>ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08    | БАТЛАВ<br>ГҮЙЦЭТГЭХ ЗЭХИРЭЛ<br>М.Ганбаатар |
|   |   | Хувилбар: 1  | Баталсан огноо:<br>2020 ойн 07 сар 06 өдөр |
|   |   | Тушаал № АН2 | ХАБЭА-н ажиглагч<br>М.Амарсайхан           |

## ГАЛ ТОГООНЫ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

| Ажилтан        | Гарын үсэг         | Овог нэр     | Албан тушаал          | Төлөв  |
|----------------|--------------------|--------------|-----------------------|--------|
| Хянасан:       | <i>[Signature]</i> | М.Анхныбаяр  | ХАБЭА-н хэсгийн дарга | Тэмдэг |
| Боловсруулсан: | <i>[Signature]</i> | Э.Амарсайхан | ХАБЭА-н ажилтан       |        |

|   |   |             |  |
|---|---|-------------|--|
|  | Гал тогооны<br>ажилтны аюулгүй<br>ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   | БАТЛАВ<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>/...../ М.Ганбаатар |
|   |   | Хувилбар: 1 | Баталсан огноо:<br>2020 он ....сар .... өдөр       |
|   |   | Тушаал №    |  |

# ГАЛ ТОГООНЫ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

| Ажилтан        | Гарын үсэг | Овог нэр     | Албан тушаал          | Төлөв  |
|----------------|------------|--------------|-----------------------|--------|
| Хянасан:       | /...../    | М.Анхныбаяр  | ХАБЭА-н хэсгийн дарга | Тэмдэг |
| Боловсруулсан: | /...../    | Э.Амарсайхан | ХАБЭА-н ажилтан       |        |

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

| БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ |                  |               |                          |
|---------------------|------------------|---------------|--------------------------|
| Хувилбар            | Өөрчлөлтийн утга | Боловсруулсан | Тушаалын<br>дугаар/Огноо |
| 1                   |                  |               |                          |
|                     |                  |               |                          |
|                     |                  |               |                          |
|                     |                  |               |                          |

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

## Агуулга

|  |    |
|--|----|
| Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага ..... | 4  |
| Хоёр. Цахилгаан зуухны аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар.....      | 5  |
| Гурав. Ширмэн тогооны аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар.....       | 5  |
| Дөрөв. Шарах шүүгээний аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар.....      | 6  |
| Тав. Хийн түлшний плитканы аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар.....  | 6  |
| Зургаа. Гурил зуурагчийн аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар.....    | 7  |
| Долоо. Шарагчийн аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар .....           | 8  |
| Найм. Жигнүүрийн аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар .....           | 8  |
| Ес. Чанагч тогооны аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар .....         | 9  |
| Арав. Ахлах тогоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа .....         | 9  |
| Арван нэг. Тогоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа .....          | 11 |
| Арван хоёр. Бэлтгэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....        | 13 |
| Арван гурав. Угаагчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа .....        | 14 |
| Арван дөрөв. Осол аваарийн үеийн аюулгүй ажиллагаа, арга хэмжээ..... | 15 |

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

**НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

- 1.1. Цахилгаанаар ажиллах тогоо, зуух, жигнүүр, шарах шүүгээ, ус буцалгагч, хурдан буцалгагч, гурил зуурагч, махны машин зэргийг ажиллуулахдаа ахлах тогоочийн өгсөн заавар зөвлөмж болон тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн зааврыг чанд мөрдөж ажиллана.
- 1.2. Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглахдаа зөвхөн ашиглалтын зааврын дагуу ажиллуулна.
- 1.3. Цахилгаан тоног төхөөрөмжийг ерөнхий тогооч болон ээлжийн ахлах тогооч ажиллуулах бөгөөд төхөөрөмжийг залгах, салгахад тогоочийн гар заавал хуурай байх ба зөвхөн “АСААХ”, “УНТРААХ” гэсэн товчлуураар гүйцэтгэнэ.
- 1.4. Цахилгаан тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ тохируулга хийхдээ цахилгаан тэжээлийг бүрэн салгаж, эргэлдэх эд ангиудыг бүрэн зогссоны дараа “БҮҮ ЗАЛГА. ХҮМҮҮС АЖИЛЛАЖ БАЙНА” гэсэн анхааруулах санамж байрлуулж мэргэжлийн засварчин, цахилгаанчнаар гүйцэтгүүлнэ.
- 1.5. Ажил дууссаны дараа ахлах тогооч буюу ээлжийн тогооч нь бүх тоног төхөөрөмжийг унтраасан эсэхийг шалгаж ерөнхий шитийг унтраах ба асаах кноп дээр “БҮҮ ЗАЛГА” гэсэн анхааруулга байрлуулна.
- 1.6. Ахлах тогооч нь ээлжийн тогоочоор ажиллах ажилтанд цахилгаанаар ажиллах тогоо, зуух, жигнүүр, шарах шүүгээ, ус буцалгагч, хурдан буцалгагч, гурил зуурагч, махны машин зэргийг ажиллуулах, ашиглах талаар заавар зөвлөмж өгч тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллуулна.
- 1.7. Хоол үйлдвэрлэлд ашиглагдаж буй цахилгаан тоног төхөөрөмжийн асаах, унтраах товчлуур болон аюултай хэсгүүдэд анхааруулах дохио санамж, тэмдэг, тэмдэглэгээг байршуулна.
- 1.8. Цахилгааны пускатель, утас, разетка, залгуур, унтраагуур, цахилгаан тоног төхөөрөмжүүдийн гагнуурын оёос, бэхэлгээний боолтууд, жийргэвчийн бүрэн бүтэн байдлыг гадна талаас нь шалгаж эвдрэлтэй бол цахилгаанчинд мэдэгдэж засварлуулна;
- 1.9. Цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгааны утас, тусгаарлагчгүй хэсэгт гар хүрэхийг хориглоно.
- 1.10. Цахилгаан тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх.

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 1.11. Тоног төхөөрөмж ажиллаж байхад ямар нэг гаж дуу чимээ гарах, хэншүү, хярвас үнэртэх, ажлын эд анги нь гэмтэх зэрэг тохиолдолд тоног төхөөрөмжийг яаралтай зогсоож, цахилгаанчинд мэдэгдэж засварлуулна.
- 1.12. Төхөөрөмжийг ажиллуулахын өмнө түүний дэргэд болон ойролцоо зогсож байгаа ажилчдад заавал анхааруулна.
- 1.13. Цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үедээ өөрийн болон бусдын анхаарлыг сарниулах, утсаар ярихыг хориглоно.
- 1.14. Гал тогоонд ашиглагдаж байгаа бүхий л цахилгаан тоног төхөөрөмж, хэрэгслийг хоосон залгаж орхихыг хатуу хориглоно.

### **ХОЁР. ЦАХИЛГААН ЗУУХНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 2.1. Цахилгаан зуухыг залгахын өмнө түүний ширэм сууриндаа хэвийн суусан, халах гадаргууд ямар нэг ан цав гарсан эсэхийг гадна талаас нь харж шалгаж гэмтэлтэй бол ахлах болон цахилгаанчинд яаралтай мэдэгдэнэ.
- 2.2. Цахилгаан зуухан дээр шингэн зүйл халаах, буцалгах, чанахдаа савны хэмжээний 80 хувиас их хийхгүй байх ба ус, тос асгахгүй байх.
- 2.3. Цахилгаан зуухны ширмийг бүрэн хөрсний дараа хуурай цэвэрлэгээ хийнэ.
- 2.4. Цахилгаан зуухан дээр буцалж байгаа халуун цай, хоолыг чирч, гулсуулах, ганцаараа өргөж авахыг хориглоно. Түлэгдэх аюултай тул болгоомжтой ажилла.
- 2.5. Цахилгаан зуухан дээр данх, саванд хоол, цай, ус тавиад залгаастай эзэнгүй орхихгүй байх, ямар нэг багаж хэрэгсэл, түүхий эд гэх мэтийг тавихгүй байх.
- 2.6. Цахилгаан зуухны ширмэнд гэмтэл гарахаас болгоомжилж ачааллыг хэтрүүлж хэт улайтгахгүй, хоол цай дэвэргэж асгахгүй байх.
- 2.7. Халуун хоол, цай, устай савыг цахилгаан зуухан дээр тавихдаа тусгай өргөх төхөөрөмжтэй тэргэнцэр хэрэглэж “өөрөөсөө гадагш” гэсэн хөдөлгөөний чиглэлээр тавина.

### **ГУРАВ. ШИРМЭН ТОГООНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 3.1. Ширмэн тогоог ажиллуулахын өмнө савны цэвэрлэгээг сайтар шалгах ба ширмийг хөрсний дараа цэвэрлэгээг хийнэ;
- 3.2. Ширмэн тогоонд мах, ногоо хуурах, цэвэрлэгээ хийхдээ зориулалтын саваа мод, хусуур зэргийг ашиглана;

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 3.3. Халуун буцалсан ус, шөлөнд бүтээгдэхүүн хийх, халуун тосонд мах, ногоог хийж хуурах үед арьс, биений хэсэг түлэгдэхээс болгоомжилж аюулгүйн зайнаас ажиллагааг гүйцэтгэнэ;
- 3.4. Буцалж буй тосонд төмс болон бусад ногоог хийхдээ ус тос үсэрхэг дусаах, халуун ууранд түлэгдэхээс болгоомжилж урьдчилан сэргийлнэ;
- 3.5. Халуун шөлтэй хоолыг тогооноос юүлэхдээ цоргонд тохируулан зориулалтын хоолны саванд авах бөгөөд халуун шөл үсрэхээс болгоомжилж аюулгүйн зайнаас ажиллагааг гүйцэтгэнэ.
- 3.6. Хоол үйлдвэрлэл явагдаж байхад тогооны гар удирдлагыг эргүүлэхийг хатуу хориглоно

### **ДӨРӨВ. ШАРАХ ШҮҮГЭЭНИЙ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 4.1. Шарах шүүгээ, шарагчийн халууны температурыг ашиглалтын зааварт зааснаас хэтрүүлэхийг хориглоно.
- 4.2. Шарах ажиллагаа явагдаж байхад хиншүү, хярвас гарвал шарагчийг нэн даруй унтраана.
- 4.3. Бүтээгдэхүүнийг шарах шүүгээнээс гаргахдаа зориулалтын зузаан даавуун бээлий хэрэглэх ба шарагчаас бүтээгдэхүүнийг авсны дараа зориулалтын тавиур дээр тавина.
- 4.4. Шарагчийн халаах гадаргууг усаар хөргөх, шарагчийг цахилгааны холболттой орхиж болохгүй.
- 4.5. Шарагчийн температурын мэдрэгч гэмтэлтэй тохиолдолд ажиллуулахыг хориглоно.
- 4.6. Шарах шүүгээ, шарагчийн хаалга нь жигд зайгүй, нягт хаагддаг байх ёстой.
- 4.7. Тоног төхөөрөмжүүдийг бүрэн хөрсний дараа хуурай аргаар цэвэрлэгээ хийнэ.

### **ТАВ. ХИЙН ТҮЛШНИЙ ПЛИТКАНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 5.1. Баллоны баталгаат хугацаа, будалт бичиглэл зэрэг нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх;
- 5.2. Баллоны хаалт вентиль гэмтээгүй эсэх;
- 5.3. Баллоны хаалтаас хий алдагдаж байгаа эсэхийг шалгах хийн түлшний плитканы холбох хоолой цуурсан эсэх;
- 5.4. Хийн түлшний плитканы очлуур хэвийн эсэх;
- 5.5. Хийн редуктор хэвийн эсэх;



|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 5.6. Хийн түлшний плитканы ойролцоо болон түүний дээр ямар нэг шатах зүйлс байгаа эсэхийг тус тус шалгана.
- 5.7. Баллоны битүүмжлэлийг савангийн уусмал ашиглан шалгаж болно.
- 5.8. Дээрхи шалгалтуудыг хийх үед тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдэд ямар нэг гэмтэл согог илэрвэл түүнийг удирдлагад мэдэгдэж заавал арилгуулсны дараа ажил гүйцэтгэнэ.
- 5.9. Ажлын үед хийн тоног төхөөрөмжийг төмөр, мод зэргээр цохих, хий дамжуулах хоолой болон хийн плитканы хаалтыг зориулалтын бус /бахь, түлхүүр, чимхүүр, хөшүүрэг гэх мэт/ зүйлээр эргүүлэх;
- 5.10. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад зааварчилга аваагүй болон гадны хүн ойртуулах;
- 5.11. Хийн тоног төхөөрөмжийг ажиллуулж дууссаны дараа хийн баллоны хаалтыг нээлттэй орхих;
- 5.12. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад түүний ямар нэг эд ангийг солих, засварлах оролдлого хийх;
- 5.13. Баллоны баталгаат хугацаа дууссан, хаалт вентиль гэмтсэн, баллоны их бие гадаргуу гэмтсэн тохиолдолд ажиллуулах;
- 5.14. Хийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх, хийн баллоныг солих үед цахилгаан төхөөрөмжүүдийг тэжээлээс нь салгасан байх ба гаднын хүн байлгах, ил гал гаргах, тамхи татах;
- 5.15. Үйл ажиллагааны явцад хийн алдагдлыг тодорхойлох зорилгоор гал ашиглахыг тус тус хориглоно;
- 5.16. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад тогтмол хяналт тавьж байх ба ямар нэг зөрчил /хий үнэртэх, очлуур ажиллахгүй байх гэх мэт / илэрвэл тэр даруй хийн тоног төхөөрөмж хариуцагчид мэдэгдэж, зөрчлийг арилгуулсны дараа ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- 5.17. Хийн тоног төхөөрөмжийг ашиглаж дууссаны дараа баллоны хаалтыг хааж холбох хоолой дахь үлдэгдэл хийг зуухны очлуурыг дарж асаан дуусгана;
- 5.18. Үйл ажиллагааны явцад хийн тоног төхөөрөмжид засвар хийх шаардлага гарвал заавал мэргэжлийн байгууллага, ажилтанд хандана.

**ЗУРГАА. ГУРИЛ ЗУУРАГЧ МАХНЫ МАШИН АЮУЛГҮЙ  
АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 6.1. Төхөөрөмжид боловсруулах бүтээгдэхүүнийг хийхийн өмнө эргэх гол нь түүний их бие дээр заасан чиглэлд эргэж байгаа эсэхийг шалгана;

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 6.2. Тоног төхөөрөмжийг хаалт, хамгаалалтгүй ажиллуулах, ремень гинжин дамжуулгыг ажиллаж байх үед нь авах хийхийг оролдохыг хатуу хориглоно;
- 6.3. Төхөөрөмжийн сольж тавьдаг хэсгүүдийг солихдоо /махны машины хутга гэх мэт/ хүчээр угзарч болохгүй ба зориулалтын багажаар авч, буцааж бэхэлнэ;
- 6.4. Махны машинд боловсруулах бүтээгдэхүүнийг хийхдээ зориулалтын түлхэгч гэх мэтийг ашиглан жигд хийнэ;
- 6.5. Махны машин ажиллаж байх үед түүнд гар, хуруугаа хүргэх, цэвэрлэхийг оролдохыг хатуу хориглоно;
- 6.6. Гурил зуурагчийг ажиллаж байх үед гар хуруугаа хүргэхгүй ба зуурч байх үед дэргэд нь хүн зогсоохыг хориглоно;

### **ДОЛОО. ШАРАГЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 7.1. Буцалж буй тосонд бүтээгдэхүүнийг хийхдээ ус дусаах, бүтээгдэхүүнийг хэт өндрөөс хийж түлэгдэхээс болгоомжилж урьдчилан сэргийлнэ;
- 7.2. Бүтээгдэхүүнийг шарах үед заавал хавчаар хэрэглэх ба боловсруулсан бүтээгдэхүүнийг гаргахдаа зориулалтын торон тавиур дээр тавина;
- 7.3. Шарагчийг усаар хөргөж болох ба шарагчийг цахилгааны холболттой орхихыг хориглоно;
- 7.4. Шарагч тогоо ажиллаж байх үед дэргэд нь хүн зогсоохыг хориглоно;
- 7.5. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж дуусаад шарагчийг унтрааж дараа нь тосыг хөртөл байлгаад тусгай зориулалтын саванд юулж авна. Юулж авахдаа цалгих, гоожихоос болгоомжилж ажиллана;

### **НАЙМ. ЖИГНҮҮРИЙН АЮУЛГҮЙ АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 8.1. Жигнүүрт бууз жигнэж дуусаад жигнүүрийн хаалгыг онгойлгохдоо халуун ууранд түлэгдэхээс болгоомжилж хаалганы эсрэг талд зогсож онгойлгоно;
- 8.2. Жигнүүртэй буузыг авахдаа гараа түлэхээс болгоомжилж зориулалтын бээлий өмсөж авна;
- 8.3. Жигнүүрт үйлдвэрлэл явагдаж байх үед халуун гадаргууд хайрагдах, түлэгдэхээс болгоомжилж ойр орчимд ажил гүйцэтгэхгүй байх;
- 8.4. Жигнүүрийг цэвэрлэхдээ хөрсний дараа тавиурыг авч цэвэрлэнэ;

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

### **ЕС. ЧАНАГЧ ТОГООНЫ АЮУЛГҮЙ АШИГЛАЛТЫН ЗААВАР**

- 9.1. Чанагч тогоог залгахын өмнө савны цэвэрлэгээ, түүний таг, хянах гэрлэн дохиолол, хамгаалах клапны нүх цэвэр, чөлөөтэй эсэх, усны төвшин хэмжигч хэвийн эсэхийг тус тус шалгана;
- 9.2. Чанах тогоонд ус, хоол буцалж байх үед тагийг онгойлгох, халуун ууранд түлэгдэхээс болгоомжилж анхаарал болгоомжтой ажиллана;
- 9.3. Халуун ус, шөлтэй хоолыг юүлэхдээ цалгих, гоожиж үсчихээс болгоомжилж аюулгүй зайнд ажиллана;
- 9.4. Хурдан буцалгагчийг ажиллуулахын өмнө түүний таг, хянах гэрлэн дохиоллуудыг шалгах;

### **АРАВ. АХЛАХ ТОГООЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- 10.1. Хоол үйлдвэрлэлийн хэсгийн бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүхий эд, материалын хангалт, нийлүүлэлтэд хяналт тавьж, үйлдвэрийн ажилчдын сэтгэл ханамжид нийцсэн эрүүл чанартай хоолоор үйлчилж гал тогооны ажилчдын аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 10.2. Ахлах тогооч нь үйлдвэрийн гал тогооны ажилтнуудад долоо хоног бүрийн эхний өдөр ажлын байран дахь зааварчилгааг ажил эхлэхийн өмнө бичгээр өгч гарын үсэг зуруулж баталгаажуулна;
- 10.3. Гал тогооны ажилтнуудын гүйцэтгэх ажлын хуваарийг нарийн оновчтой зохион байгуулж өглөө бүр үндсэн чиг үүрэг өгч өмнөх өдрийн гаргасан амжилт, зөрчил дутагдалд дүгнэлт хийж, хоолны технологи болон аюулгүй ажиллагаанд анхаарч, ажлын дүрэмт хувцас, бусад хэрэгслийг зөв гүйцэт өмсгөж, ажлын байранд хэрэглэж хэвшүүлнэ;
- 10.4. Ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээг Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтантай хамтран боловсруулна;
- 10.5. Ажлын байран дахь аюулыг олж илрүүлэх, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, ажилбар бүрийн бүх шатанд байнгын хяналт тавьж ажилтнуудаас аюулыг мэдээлэх хуудсаар мэдээлэл авч ХАБЭА-н хэсэгт ирүүлнэ;
- 10.6. Цахилгаан тоног төхөөрөмжийн ерөнхий унтраагуурыг /шит/ зөвхөн ерөнхий тогооч залгаж, салгана.
- 10.7. Ээлжийн тогоочоор ажиллах ажилтанд цахилгаанаар ажиллах тогоо, зуух, жигнүүр, шарах шүүгээ, ус буцалгагч, хурдан буцалгагч, гурил зуурагч, махны машин зэргийг ажиллуулах, ашиглах талаар заавар зөвлөмж өгч тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллуулна.

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 10.8. Хоол үйлдвэрлэлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжид анхааруулага санамжуудыг байршуулна.
- 10.9. Ахлах тогооч нь хөлдөөх төхөөрөмжийг хариуцан ажиллах бөгөөд бүтээгдэхүүнийг, тохирсон температурт хадгална.
- 10.10. Хөлдөөх төхөөрөмжид хийсэн бүтээгдэхүүнийг авахдаа хурц үзүүртэй, ирмэгтэй багаж ашиглахыг хориглоно.
- 10.11. Гал тогооны ажилчдын болон өөрийн эрүүл мэндэд ямар нэг зовиур илрэх, үйлдвэрлэлийн осол гарах, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох аливаа зөрчил илэрвэл тухай бүр үйлдвэрийн эмч, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэнэ.
- 10.12. Ажлын байрыг эмх цэгцтэй байлгаж орох, гарах гарцыг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд, хайрцаг саваар хааж таглахгүй байхад хяналт тавих.
- 10.13. Ажилчдын ажлын байранд хариуцсан эд зүйлийн бүрэн бүтэн байдал, гэнэтийн осол гаргахаас урьдчилан сэргийлж ажиллах, хувийн ариун цэвэр болон хүнсний аюулгүй байдлыг хангуулах.
- 10.14. Ажилчдыг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар мөрдөөгүйгээс осол, гэмтэл, бэртэл авах, хүнсний аюулгүй байдал хангаагүйгээс хордлого, халдвар гарахаас урьдчилан сэргийлэх.
- 10.15. Үйлчилгээний болон хоол бэлтгэлийн заалыг тогтмол цэвэр байлгаж, тусгай ариутгалын бодисоор цэвэрлэгээг хийлгэх.
- 10.16. Тухайн өдрийн хоолны цэс, зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ болон ариун цэврийн талаар санамж бүхий анхааруулгыг үйлчлүүлэгчдэд харагдахуйцаар хананд байрлуулж хэвших.
- 10.17. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний хадгалалт, шинж чанараас хамааран зориулалтын хөргүүр, хөлдөөгч, агуулахад хадгалах.
- 10.18. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалалтын нөхцөлийн дагуу, эмх цэгцтэй хадгалж, гэмтэж муудах, бохирдохоос сэргийлэн хадгалалтын хугацаанд хэрэглэнэ.
- 10.19. Ажил эхлэхийн өмнө дараах зүйлийг шалгаж бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана. Үүнд:
- Гал тогооны багаж хэрэгсэл, сав суулга, чанагч тогоо, аяга тавагны цэвэрлэгээ, тоо ширхэг;
  - Тоног төхөөрөмжийн халах гадаргууд ямар нэг ан цав гарсан байдал, эргэлдэх болон хөдөлгөөнт эд ангиудын бэхэлгээ хэвийн байгаа эсэхийг гадна талаас нь харж шалгана;
  - Ажлын байран дахь агааржуулалт, гэрэлтүүлэг хэвийн эсэх;

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- Цахилгааны пускатель, утас, разетка, залгуур, унтраагуур, тоног төхөөрөмжүүдийн гагнуурын оёос, бэхэлгээний боолтууд, жийргэвчийн бүрэн бүтэн байдлыг гадна талаас нь шалгаж эвдрэлтэй бол цахилгаанчинд мэдэгдэж засварлуулна;
- Ажлын байран дахь зам, гарц чөлөөтэй эсэх, хоол үйлдвэрлэлийн сав суулга, түүхий эд, болон бусад зүйлсийг тохиромжтой байрлуулсан эсэх;
- Хоол үйлдвэрлэлийн сандал, ширээ, тавиурын гадаргуугийн тэгш байдал болон ямар нэгэн ан цав, цууралттай эсэхийг шалгаж эвдрэл гэмтэлтэй бол арга хэмжээ авна.
- Ажлын үед хэрэглэх хутга, шанага, хутгуур, хавчаар зэрэг багажнуудын бариул нь найдвартай бэхлэгдсэн, гар хуруу гулгаж зүсэгдэхээс хамгаалах хамгаалалттай, ямар нэг гэмтэлгүй байгаа эсэх;
- Хяналт, хэмжилт, тохируулгын хэрэгслүүд /лац, ломбо, даралтат савны үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа, даралт хэмжүүрийн зүү “0” заалт дээр байгаа эсэх, шилний бүрэн бүтэн байдал, хэмжилт хяналтын хэрэгслийн гадна талд механик гэмтэлтэй эсэх гэх мэт/-ийг хянах;
- Гал тогооны шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж, ариутгах ба их цэвэрлэгээг 7 хоног тутамд хийлгэх;
- Хоол үйлдвэрлэх хэсэг болон ажилчдын хооллох заалны шал нойтон, гулгаатай, тэгш бус, байгаа эсэхийг тус тус шалгаж хяналт тавина;

### **АРВАН НЭГ. ТОГООЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- 11.1. Долоо хоног бүрийн эхний өдөр ахлах тогоочоос аюулгүй ажиллагааны зааврыг бичгээр авч баталгаажуулж гарын үсэг зурна.
- 11.2. Ажил эхлэхийн өмнө гадуур хувцас, малгай, гутал, бусад зүйлийг тайлж хувцасны шүүгээнд хийж, гараа заавал савандаж угаасан байна.
- 11.3. Ахлах тогоочоос тухайн өдөр гүйцэтгэх ажлын нарядыг авч аюулгүй байдалдаа анхаарч ажиллана.
- 11.4. Ажлын байранд ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг өмсч товчийг бүрэн товчилж, үсээ зориулалтын малгайгаар халхалж /урт үстэй бол үсийг шууна/, хувцсандаа ямар нэгэн зүү, хайч, хутга гэх мэт биед гэмтэл цочрол үзүүлж болох хурц үзүүртэй зүйл авч явахгүй байх ба ээмэг, бөгж, цаг, хүзүүний зүүлт зэргийг авч, хумсаа богиносгож, хумсны лак түрхээгүй байна.

|  |             |
|--|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|  | Хувилбар: 1 |

- 11.5. Бие засах газар орох бүрдээ гараа савандаж угаах ба ажлын хувцсыг бохирдсон тухай бүр цэвэрлэж хэрэглэнэ.
- 11.6. Халуун зүйлтэй харьцахдаа заавал гар хамгаалах бээлий өмссөн байна.
- 11.7. Цахилгаанаар ажиллах тогоо, зуух, жигнүүр, шарах шүүгээ, ус буцалгагч, хурдан буцалгагч, гурил зуурагч, махны машин зэргийг ажиллуулахдаа ахлах тогоочийн өгсөн заавар зөвлөмж болон тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөж ажиллана.
- 11.8. Хутгатай харьцаж ажиллахдаа гараа зүсэхээс болгоомжлон ажиллах ба ашиглаагүй үед заавал хамгаалалтын гэр, уутанд хийнэ.
- 11.9. Бүтээгдэхүүнийг зүсэхдээ зориулалтын хутга хэрэглэх ба янз бүрийн хэлбэр гаргаж зүсэх бол мөн тусгай хутга хэрэглэнэ.
- 11.10. Ажил гүйцэтгэж байх үедээ хутгыг гартаа барьж явах, ирийг нь гараараа шалгах, огцом эргэлт, хөдөлгөөн хийх, овор ихтэй бүтээгдэхүүн, түүхий эд авахыг оролдох зэргийг хориглоно.
- 11.11. Халуун боловсруулалт хийж байх үед арьс түлэгдэлтээс болгоомжилж аюулгүй зайнаас ажиллагааг гүйцэтгэнэ.
- 11.12. Хоолтой сав суулгыг найдвартай, тогтвортой тэгш гадаргуутай тавиур буюу плиткэн дээр тавина.
- 11.13. Хоол боловсруулах савны ёроол гэмтэлтэй байх, бариул нь найдвартай бэхэлгээгүй байх, ан цав, цууралттай байхад ашиглахыг хориглоно.
- 11.14. Халуун хоолтой савыг зөөвөрлөхдөө ойр орчинд ямар нэг саад болох зүйл байгаа эсэхийг шалгаж, орчныг саадгүй болсны дараа зөөвөрлөнө.
- 11.15. Халуун хоол, цайтай савыг хэт дүүргэж бялхаахгүй зөөвөрлөх бөгөөд зөөх үед гартаа ямар нэг зүйл давхар барьсан байхыг хориглоно. Гараар ачаа өргөх стандартын хэмжээнээс хитэрсэн бол цуг зөөвөрлөх хүнтэйгээ харилцан ойлголцож анхааруулсны дараа хуурай бээлий хэрэглэж, биеэс хөндий дамжилж зөөвөрлөнө.
- 11.16. Хоолтой савыг плиткэн дээр тавихдаа тусгай өргөх төхөөрөмжтэй тэргэнцэр хэрэглэж “өөрөөсөө гадагш” гэсэн хөдөлгөөний чиглэлээр тавина.
- 11.17. Буцалж буй тосонд төмс болон бусад ногоог хийхдээ ус дусаах, чанах тогоо, халуун хоолтой савнуудын тагийг болгоомжтой онгойлгож түлэгдэхээс урьдчилан сэргийлнэ.
- 11.18. Гал тогооны халуун цайтай, хоолтой, сав суулгыг алчуур, бээлий хэрэглэж барих ба буцалсан тостой савыг хүн явахгүй газар байршуулна.
- 11.19. Ажил гүйцэтгэж байх үедээ хөгжим сонсох, утсаар ярих, нэмэлт тоноглол ашиглан бичлэг үзэхийг хориглоно.

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

11.20. Ажил гүйцэтгэж байхад өөрийн болон бусад ажилчдын биед ямар нэг зовиур илрэх, болон амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох аливаа зөрчил илэрвэл ахлах тогооч болон үйлдвэрийн удирдлагад яаралтай мэдэгдэж уг зөрчлийг арилгуулсны дараа ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

### **АРВАН ХОЁР. БЭЛТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- 12.1. Бэлтгэгч нь долоо хоног бүрийн эхний өдөр ахлах тогоочоос аюулгүй ажиллагааны зааврыг бичгээр авч баталгаажуулж гарын үсэг зурна.
- 12.2. Ажил эхлэхийн өмнө гадуур хувцас, малгай, гутал, бусад зүйлийг тайлж хувцасны шүүгээнд хийж, гараа заавал савандаж угаасан байна.
- 12.3. Ахлах тогоочоос тухайн өдөр гүйцэтгэх ажлын нарядыг авч аюулгүй байдалдаа анхаарч ажиллана.
- 12.4. Ажлын байранд ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг өмсч товчийг бүрэн товчилж, үсээ зориулалтын малгайгаар халхалж /урт үстэй бол үсийг шууна/, хувцсандаа ямар нэгэн зүү, хайч, хутга гэх мэт биед гэмтэл цочрол үзүүлж болох хурц үзүүртэй зүйл авч явахгүй байх ба ээмэг, бөгж, цаг, хүзүүний зүүлт зэргийг авч, хумсаа богиносгож, хумсны лак түрхээгүй байна.
- 12.5. Бие засах газар орох бүрдээ гараа савандаж угаах ба ажлын хувцсыг бохирдсон тухай бүр цэвэрлэж хэрэглэнэ.
- 12.6. Хүнсний материал, түүхий эдийг ерөнхий тогоочоос хүлээн авч, тогоочийн заавраар, тухайн өдрийн бэлдцийг технологийн дагуу гүйцэтгэнэ.
- 12.7. Түүхий эд, материалыг зориулалтын сав, хайрцагт жин хэтрүүлэхгүйгээр хийж зөөвөрлөнө.
- 12.8. Овор ихтэй хүнсний бараа, материалыг зөөж, хураахдаа болгоомжтой, зөөвөрлөгч хамтрагчтай ажиллана.
- 12.9. Ажил эхлэхийн өмнө багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг анхаарч зөвхөн зориулалтын багаж ашиглах бөгөөд гэмтэлтэй тохиолдолд ерөнхий тогооч болон ээлжийн тогоочид мэдэгдэж засварлуулсны дараа ажлаа гүйцэтгэнэ.
- 12.10. Үйлчилгээ эхлэхийн өмнө хооллох танхимын ширээ сандлыг байрлуулж, ширээн дээр хоол амтлагч, цаасан амны алчуур, үйлчилгээний хэлбэрээс хамааруулан нэмэлт засал хийнэ.
- 12.11. Ажил гүйцэтгэх үедээ зориулалтын, төрөл бүрийн багаж хэрэгсэл ашиглавал үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчээс гаргасан аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөж ажиллана.

|   |             |
|---|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|   | Хувилбар: 1 |

- 12.12. Хайрцаг савтай, таглаатай, лаазалсан бүтээгдэхүүнийг онгойлгохдоо зориулалтын багаж хэрэглэх ба ямар нэг зүйлийг орлуулан хэрэглэхийг хориглоно.
- 12.13. Мах эвдэж, шулж, жижиглэхдээ тусгай өрөөнд дэвсгэр, вандан дээр үйлдэнэ. Хутга, сүх, заазуур нь хурц иртэй бат бөх байх бөгөөд гар хуруугаа зүсэхээс болгоомжилно.
- 12.14. Том оврын сав болон хоолны бэлдцүүдийг эмх цэгцтэй бусад ажилчдад саад болохооргүй байршуулна.
- 12.15. Том овор ихтэй маслыг утас ашиглан хуваахдаа утсыг гараараа татахыг хориглоно.
- 12.16. Хоол бэлтгэх технологийн явцад гурил, крахмал зэрэг ажлын байрны агаарыг бохирдуулах ажиллагааг тусгай бэлтгэлийн өрөөнд явуулна.
- 12.17. Ажил гүйцэтгэж дууссаны дараа гар багаж хэрэгслийг шүүгээ саванд хийж байр, байранд нь байршуулж хэвших.
- 12.18. Ажлын байранд янз бүрийн хайрцаг, саван дээр суухыг хориглоно.
- 12.19. Ажил гүйцэтгэж байх үедээ хөгжим сонсох, утсаар ярих, нэмэлт тоноглол ашиглан бичлэг үзэхийг хориглоно.

### **АРВАН ГУРАВ. УГААГЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- 13.1. Угаагч нь долоо хоног бүрийн эхний өдөр ахлах тогоочоос аюулгүй ажиллагааны зааврыг бичгээр авч баталгаажуулж гарын үсэг зурна.
- 13.2. Ажил эхлэхийн өмнө гадуур хувцас, малгай, гутал, бусад зүйлийг тайлж хувцасны шүүгээнд хийж, гараа заавал савандаж угаасан байна.
- 13.3. Ахлах тогоочоос тухайн өдөр гүйцэтгэх ажлын нарядыг авч аюулгүй байдалдаа анхаарч ажиллана.
- 13.4. Ажлын байранд ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг өмсч товчийг бүрэн товчилж, үсээ зориулалтын малгайгаар халхалж /урт үстэй бол үсийг шууна/, хувцсандаа ямар нэгэн зүү, хайч, хутга гэх мэт биед гэмтэл цочрол үзүүлж болох хурц үзүүртэй зүйл авч явахгүй байх ба ээмэг, бөгж, цаг, хүзүүний зүүлт зэргийг авч, хумсаа богиносгож, хумсны лак түрхээгүй байна.
- 13.5. Бие засах газар орох бүрдээ гараа савандаж угаах ба ажлын хувцсыг бохирдсон тухай бүр цэвэрлэж хэрэглэнэ.
- 13.6. Бохирдсон аяга, тавга, сав суулгыг угаахдаа халуун усны крантыг болгоомжтой онгойлгох бөгөөд зориулалтын бээлийг заавал хэрэглэнэ.
- 13.7. Крантны усыг нээж хаахдаа болгоомжтой аажуухан эргүүлж онгойлгож хаах ба зориулалтын бус алх, түлхүүр зэргийг ашиглахыг хориглоно.
- 13.8. Угааллагын явцад шалан дээр ямар нэг бүтээгдэхүүн, ус, тос асгарсан бол даруй цэвэрлэнэ.



|  |             |
|--|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|  | Хувилбар: 1 |

- 13.9. Угаах болон ариутгах шингэнийг бэлтгэхдээ эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээгээр бэлтгэх ба шингэний температурыг 50 градусаас хэтрүүлэхгүй байлгаж, гар дээрээ дусаахаас болгоомжилж, хэрэглэхдээ тоосруулж цацахыг хориглоно.
- 13.10. Үйлдвэрлэлийн явцад ажлын бүсэд тос, ус, гурил, крахмал зэргээр бохирдсон бол ажлаа зогсоож, кальцжуулсан содын уусмал, чийгтэй цэвэрлэгээ хийсний дараа ажлаа үргэлжлүүлнэ.
- 13.11. Хоол унд хийж дууссаны дараа аяга, таваг, сав, суулгаа угааж, багаж хэрэгслээ арчин цэвэрлэж, зориулалтын саванд байрлуулж, хоолны үлдэгдлийг зайлуулж зориулалтын нүхэнд асгаж, ажлын байраа цэвэрлэнэ.
- 13.12. Гал тогооны шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэх бөгөөд хооллох өрөөний шалыг хуурай цэвэр байлгаж шалан дээр асгарсан тос, шингэнийг даруй арчиж аюулгүй болгоно.
- 13.13. Ажил гүйцэтгэж байхдаа чийгтэй гараар цахилгааны утсанд хүрэх, залгуур залгахыг хориглоно.
- 13.14. Цэвэрлэгээний багаж хэрэгслийг тусгай байранд хадгалж, тэдгээрийг цэвэрлэгээ хийж дууссаны дараа халуун усаар угааж, ариутгалын бодисоор халдваргүйжүүлнэ.
- 13.15. Ажлын үед өөрийн болон бусдын анхаарлыг сарниулахгүй байх, анхаарал болгоомжтой ажиллах, гал тогооны өрөөнд гадны хүн оруулахыг хатуу хориглоно.
- 13.16. Ерөнхий болон ээлжийн тогоочийн зөвшөөрөлгүйгээр цахилгааны шитийг залгаж, салгахыг хориглоно.

### **АРВАН ДӨРӨВ. ОСОЛ АВААРИЙН ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ**

- 14.1. Үйл ажиллагааны явцад тоног төхөөрөмжид ямар нэг гэмтэл илэрвэл юуны өмнө цахилгаан тэжээлийг салгаж, нэмж бүтээгдэхүүн хийлгүй, ажлын удирдагчид мэдэгдэнэ.
- 14.2. Осол аваарийн үед ажиллах журмын дагуу ойр орчимд байгаа хүмүүсийг аюулгүй газар шилжүүлнэ.
- 14.3. Ажлын бүсэд шатдаг хий үнэртвэл хамраа нойтон салфеткаар таглаж, цонх хаалгыг онгойлгож, агааржуулах, хий дамжуулах хоолойн крантыг хаана. Энэ үед цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, агааржуулалтын системийг ажиллуулах, ил гал гаргахыг хатуу хориглоно.
- 14.4. Ослын үед хүн осолдвол эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх ба шаардлагатай бол түргэн тусламж дуудаж, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авна.
- 14.5. Тос хэт халснаас гал гарч шатвал тэр даруй зузаан даавуу зэргээр бүтээж унтраана.

|  |             |
|--|-------------|
| Гал тогооны ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа | ТТТ-АА-08   |
|  | Хувилбар: 1 |

14.6. Хийн тоног төхөөрөмж ашиглаж байх үед хий алдагдаж, үнэртэж эхэлсэн тохиолдолд мэргэжлийн байгууллага, хүмүүст яаралтай мэдэгдэж, доорхи арга хэмжээг эхний ээлжид авна.

- Хийн тоног төхөөрөмж унтраах;
- Баллоны хаалтыг сайн хаах;
- Цахилгаан унтраалга, залгуур зэргээс оч хаяж, богино холбоо үүсэхээс сэргийлэн асаалттай чийдэнг унтраахгүй байх;
- Нэмж цахилгаан тоног төхөөрөмж залгахгүй байх;
- Хамраа нойтон салфеткаар таглаж, цонх хаалгыг онгойлгож агааржуулах ба ил гал гаргахыг хатуу хориглоно.